



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 01 сарын 28 өдөр

Дугаар Б/04

Ховд

С.Ганзоригт урамшуулал олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1.4, Аймгийн Онцгой комиссын 2022 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн “Шуурхай арга хэмжээ авах тухай” 05 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын тунд хамрагдвал зохих иргэдийн 88.4 хувийг хамруулж зохион байгуулсан Дуут сумын Засаг дарга С.Ганзоригийг үндсэн цалингийн 20 хувиар тооцож урамшуулсугай.
2. Урамшуулалыг тооцож олгохыг тус сумын Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогчид зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ